



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 20 өдөр

дугаар 1/38

Өлгий

Авлигын эсрэг үйл ажиллагааны
2022 оны төлөвлөгөөг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх “Авлигын эсрэг үйл ажиллагааны 2022 оны төлөвлөгөө”-г хавсралтаар баталсугай.
2. Авлигын эсрэг үйл ажиллагааны 2022 оны төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажиллахыг холбогдох байгууллагын дарга, сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.
3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Б.Мухамед)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.БАУЫРЖАН



0101220897



Аймгийн Засаг дартын 2022 оны
01... сарын 20 өдрийн 11:30 тоот
захирамжийн хавсралт

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2022.01.20

Өлгий хот

Зорилт	№	Үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хариуцах байгууллага
1. АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ИРГЭДЭД СУРТАЛЧЛАХ, СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ, АЛБАН ХААГЧДЫГ СУРГАЛТАД ХАМРУУЛАХ	1.1	АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн сум, байгууллагын хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (facebook, twitter, youtube), лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэх	Жилийн турш	Сумдын Засаг даргын Тамгын газар, байгууллага, агентлагууд
	1.2	АТГ-аас санаачилсан аян, арга хэмжээг байгууллага, салбар нэгж, нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан зохион байгуулах		
	1.3	Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах		
	1.4	Авлигын эсрэг сургалтын санал, захиалгыг төлөвлөгөөнд тусгзуулахаар 01 дүгээр сарын 25-ны дотор АТГ-ын УССГХ-т хүргүүлэх	01 дүгээр сард	ТЗУХэлтэс
	1.5	АТГ-аас зохион байгуулдаг авлигын эсрэг анхан шатны сургалтад албан хаагчдаа хамруулах	Тухай бүр	ТЗУХэлтэс ХЭЗХэлтэс
	1.6	АТГ-аас зохион байгуулдаг авлигын эсрэг давтан сургалтад албан хаагчдаа хамруулах	Тухай бүр	ТЗУХэлтэс ХЭЗХэлтэс

	1.7	Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоо, сургач багшаар дамжуулан иргэд, хүүхэд залууст хүргэх шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулж, үр дүн тооцож, тайлагнасан байх;	Жилийн турш	ТЗҮХэлтэс ХЭЗХэлтэс Сургач багш нар
	1.8	Авлигын эсрэг боловсрол олгох агуулгыг бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөр, стандартад тусгах, оюутан, сургач, эцэг, эхийг хамруулсан шударга ёсны сэдэвт өдөрлөг, сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулах.	Жилд	Нийгмийн бодлогын хэлтэс, Боловсрол, шинжлэх ухааны газар,
2. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРААС ГАРГАСАН ШИЙДВЭРИЙГ БИЕЛҮҮЛЭХ	2.1	Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх	Тухай бүр	Аймаг, сумдын ЗДТГазар, Байгууллага, агентлагууд
	2.2	Мөрдөгчийн мэдэгдэлд тусгагдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх		
	2.3	Зөрчил арилгуулах албан бичигт тусгагдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх		
	2.4	Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг шинэ арга хэлбэрт шилжүүлэх, дотоод хяналтын тогтолцоог бурдүүлэх.		
3. БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГЫН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХҮСЭЛ ЭРМЭЛЗЭЛ, САНААЧИЛГА ӨРНҮҮЛЭХ	3.1	Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэдээс гаргасан санал, санаачилгыг дэмжин туслах	Жилийн турш	Аймаг, сумдын ЗДТГ Байгууллага, агентлагууд
	3.2	Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ, хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах		
4. АВЛИГА, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ ҮҮСГЭХ ШАЛТГААН НӨХЦӨЛИЙГ АРИЛГУУЛАХ	4.1	Авлигын эрсдэл ба авлига гарах нөхцөлийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, шат дамжлагыг бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх	Жилийн турш	Аймаг, сумдын ЗДТГ Байгууллага, агентлагууд

5. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД, • НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ	5.1	Шилэн дансны тухай хуулийн 6.1, 6.4, Авлигын эсрэг хуулийн 6.1.4, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7.1.9-т заасан заалтуудын хэрэгжилтийг хангаж ажиллах	Тухай бүр	Аймаг, сумдын ЗДТГазар, Байгууллага, агентлагууд
	5.2	Төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх.	Тухай бүр	Төрийн үйлчилгээ-мэдээллийн төв, сумдын ЗДТГазар, байгууллага, агентлагууд
	5.3	Аймаг, сумдын Засаг даргын болон байгууллагын даргын шийдвэрийг олон нийтэд мэдээлэх, сурталчлах, ил тод, нээлттэй байх зорилгоор албаны цахим хуудаст тухай бүр байршуулах,		
6. ТӨРИЙН АЛБАНЫ ТӨВ БАЙГУУЛЛАГЫН ДҮГНЭЛТ, ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН УРЬДЧИЛСАН МЭДҮҮЛГИЙГ ХЯНАСАН БАЙДЛЫГ ҮНДЭСЛЭН АЛБАН ТУШААЛД ТОМИЛОХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ, ХАРИУЦЛАГЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ.	6.1	Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, тогтоол болон нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг(ХАСҮМ)-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох	Тухай бүр	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Төрийн албаны салбар зөвлөл
	6.2	Төрийн захиргааны байгууллагын хүний нөөцийн жагсаалт, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг ил тод, нээлттэй болгох.		
7. ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЖУРМЫГ ХЯЛБАРЧИЛЖ, ТҮҮНД ТАВИХ ХЯНАЛТЫН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЭХ, ЗАРИМ ТӨРЛИЙН ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ХЯНАЛТ ТАВИХ ЧИГ ҮҮРГИЙГ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГАД ШИЛЖҮҮЛЭХ.	7.1	Тухайн байгууллагаас олгож байгаа зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, зөвшөөрөл эрхлэх дүгнэлт эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/-ийн журам болон жагсаалтын гаргаж цахим хуудсандaa байршуулсан байх.	Тухай бүр	Хууль эрх зүйн хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтэс, Стандарт, хэмжил зүйн хэлтэс, ОбГазар, МХГазар, Сумдын Засаг дарга
	7.2	Тухайн зөвшөөрөл, гэрчилгээ эзэмшигчийн нэр, хаяг, үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандaa ойлгомжтой байдлаар байршуулах.		

	8.1	Хувь хүн, хуулийн этгээдээс төсвийн байгууллагад өгсөн хандив, тусlamж гэх мэт төсвийн бус орлого, түүнийг олон нийтэд мэдээлэх.	Тухай бүр Төсвийн тухай хуульд заасан хугацаанд	Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, сумдын ЗДТГазар,
8. УЛСЫН ТӨСӨВ БОЛОН ОРОН НУТГИЙН ТӨСӨВ, САНХҮҮГИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООГ САЙЖРУУЛАХ, ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ ХАРИУЦЛАГТАЙ БАЙХ ЗАРЧМЫГ МӨРДҮҮЛЭХ.	8.2	Шилэн дансны тухай хуулийн дагуу төсөв, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг ил тод болгох Тухайн жилийн төсөв /1-р сарын 10-ны дотор/, өмнөх оны төсвийн гүйцэтгэл /4 дүгээр сарын 1-ний дотор/, дараа жилийн төсвийн төсөл /8 дугаар сарын 15-ны дотор/-ийг цахим хуудсанд байршуулах.		
	8.3	Жилийн эцсийн санхүүгийн тайланг болон санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах.	Тухай бүр Төсвийн тухай хуульд заасан хугацаанд	Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Сумдын Засаг даргын Тамгын газар, байгууллага, агентлагууд
	8.4	Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулан олон нийтэд мэдээлэх.		
	8.5	Концессын зүйлийн жагсаалт баталсан ИТХ-ын шийдвэрийг цахим хуудсанд байршуулах /нэмэлт өөрчлөлт орсон бол батлагдсанаас хойш ажлын 14 хоногийн дотор цахим хуудсанд байршуулах .		
	8.6	Орон нутгийн төсвийн төслийн талаар хэлэлцүүлэг өрнүүлэх, төсвийн төсөлд олон нийтийн саналыг авч тусгах .		
9. ТӨСВИЙН ТӨСӨЛ ХЭЛЭЛЦЭХЭД ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ.	9.1	Орон нутгийн төсвийн төсөлд санал авах хэлэлцүүлэгийн талаар Засгийн газрын www.iltod.mn , www.shilendans.mn цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд мэдээлэх.	Тухай бүр	Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хөрөнгө оруулалт, хөгжлийн

	9.2	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийх ажлыг төлөвлөх, батлахад иргэдийн оролцоог хангах талаар хийсэн хэлэлцүүлгийн баримтыг архивын нэгж болгон хадгалах	Тухай бүр	бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Сумдын Засаг даргын Тамгын газар, байгууллага, агентлагууд ,
10. ТЕНДЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БОЛГОЖ, ЦАХИМ ХЭЛБЭРТ БҮРЭН ШИЛЖҮҮЛЭХ.	10.1	Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийг бүртгэлд хамруулан тухайн аж ахуйн нэгжийн талаарх мэдээллийг захиалагч байгууллагаас холбогдох байгууллагад хүргэх тогтолцоог бүрдүүлэх.	Жилд	Орон нутгийн өмчийн газар
	10.2	Худалдан авах үйл ажиллагааны бүх тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулах, худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтын зарыг www.bayan-olgii.gov.mn , байгууллагын албан ёсны цахим хуудас болон орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр тухай бүр зарлан нийтэд мэдээлэх, байршуулах.	Жилд	Орон нутгийн өмчийн газар
	10.3	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг олон нийтэд танилцуулах, хэлэлцүүлэх, батлагдсан баримт бичгийг цахим хуудас www.bayan-olgii.gov.mn , байгууллагын цахим хуудаст тогтмол байршуулах, иргэний нийгмийн байгууллагыг татан оролцуулах.	Тухай бүр	Аймгийн ИТХ-ын ажлын алба, Хууль эрх, зүйн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар

-----ооОоо-----